

Соёлын Төв Өргөө



2019 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ

Гарчиг

1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн3
2. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, үр дүн3-9
3. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн 9-36
4. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал37
5. Бусад мэдээлэл, Цаг үеийн шаардлагаар хийсэн ажлын үр дүн37-41

СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨНИЙ 2019 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэг. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн:

Өргөө нь Монгол Улсын хууль, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 хөтөлбөр, Улсын Их Хурлаас 2012 онд баталсан “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого, Засгийн Газраас батлагдсан төсөл хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан “Нийслэлийн хүн амд үзүүлэх соёл, урлагийн үйлчилгээний нэр төрлийг олшруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, соёл урлагийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх” зорилтууд, байгууллагын үйл ажиллагаанд мөрдөхөөр батлагдсан дүрэм, журам, зааврыг хэрэгжүүлж ирлээ. Тухайлбал:

- Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар төрийн үйлчилгээний албанд тавигддаг зарчим, шаардлага болон холбогдох заалтууд, нийслэлийн өмчийн эд хөрөнгийг бэлтгэх, бүртгэх, ашиглах, хамгаалах, түрээслэхэд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Архивын тухай хууль, НИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж ирлээ.
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нутгийн захиргааны байгууллагуудын бодлого, үйл ажиллагаа, хэрэгжилт, үр дүн бүх түвшинд ил тод нээлттэй, хариуцлагатай болж, иргэдийн хяналтыг бий болгон, сайн засаглалтай хот болгохоор дэвшүүлсэн зорилтыг байгууллагынхаа үйл ажиллагаанд хэрэгжүүлж ажиллаж байна.

Хоёр: Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, үр дүн.

2.1. Байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хугацаа.

Байгууллагын үйл ажиллагааны тайланг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын **01 дүгээр хавсралтын** дагуу бодлогын баримт бичиг, захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилийн байдлаар гаргаж, холбогдох материалын хамт НЗДТГ-ын Хяналт Шинжилгээ Үнэлгээний хэлтэст хүргүүлдэг болж хэвшлээ.

2.2. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт:

2.2.1. Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлт

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖИЙН БИЕЛЭЛТ

Нийслэлийн Соёлын Төв өргөө 2019 он

Д/Д	Арга хэмжээ болсон он сар өдөр	Захирамж гарсан он сар өдөр дугаар	Товч утга	Биелэлт	Мөнгөн дүн
-----	--------------------------------	------------------------------------	-----------	---------	------------

1.	2019.01.24	2013.01.18 A/33	Жагсаалт батлах, төлбөрөөс чөлөөлөх	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчдын зөвлөгөөнийг 2019 оны 1 дүгээр сарын 24-ны 10.00-13.00 цагт зохион байгууллаа. 3 цаг	9000000
2.	2019.02.21	2013.01.18 A/33	Жагсаалт батлах, төлбөрөөс чөлөөлөх	Орон нутгийн удирдах ажилтны зөвлөгөөний төлөөлөгчдөд зориулсан концертыг 2019 оны 2 дугаар сарын 21-ны 20.00-22.00 цагт 2 цаг, концертын сургуулилтыг 2019 оны 2 дугаар сарын 20-ны 11.00-14.00 3 цаг	7500000
3.	2019.03.05	2013.01.18 A/33	Жагсаалт батлах, төлбөрөөс чөлөөлөх	Нийслэлийн удирдах ажилтны өргөтгөсөн шуурхай зөвлөгөөнийг 2019 оны 3 дугаар сарын 05-ны 11.00-14.00 цагт зохион байгуулав. 3 цаг	9000000
4.	2019.03.14	2019.02.12 A/85	Монгол цэргийн өдөр Зэвсэгт хүчний 98 жилийн ойг тэмдэглэх тухай	Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 98 жилийн ойг тохиолдуулан “Төрийн батлан хамгаалах үйлчилгээний өдөрлөг”-ийг 2019 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 11.00-17.00 цагийн хооронд зохион байгуулав. 6 цаг	18000000
5.	2019.04.12	2013.01.18 A/33	Жагсаалт батлах, төлбөрөөс чөлөөлөх	Монголын багш нарын VII их хурлын төлөөлөгчдөд зориулсан концертыг 2019 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 15.00-17.00 цагт зохион байгуулав. 2 цаг, сургуулилт 3 цаг	7500000
6.	2019.04.21	2013.01.18 A/33	Жагсаалт батлах, төлбөрөөс чөлөөлөх	УИХ-ын гишүүн Саранчимэгийн БЗД-ийн иргэдтэй хийсэн уулзалтыг 2019 оны 04 дүгээр сарын 21-ны 12.00-15.00 цагт зохион байгуулав. 3 цаг	9000000
7.	2019.05.30	2013.01.18 A/33	Жагсаалт батлах, төлбөрөөс чөлөөлөх	Монгол Улсын ерөнхий сайд У.Хүрэлсүхийн олон улсын энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцож байгаа цэргийн алба хаагчид, тэдний гэр бүлийнхэнтэй хийх уулзалтыг 2019 оны 5 дугаар сарын 31-ны 11.00-15.00 цагт зохион байгуулав. 4 цаг	12000000
8.	2019.06.01	2013.01.18 A/33	Жагсаалт батлах, төлбөрөөс чөлөөлөх	Одонтой ээжүүдэд хүндэтгэл үзүүлэх, 555 ээжид алдарт эхийн одон гардуулах ёслолын арга хэмжээг 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 11.00-14.00 цагийн хооронд зохион байгуулав. 3 цаг	9000000
9	2019.06.12,2 019.06.16	2013.01.18 A/33	Жагсаалт батлах, төлбөрөөс чөлөөлөх	Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн ивээл дор Олон улсын ардын урлагийн их наадмыг 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдрүүдэд зохион байгуулав. 30 цаг	90000000

10	2019.06.21	2013.01.18 A/33	Жагсаалт батлах, төлбөрөөс чөлөөлөх	Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн ивээл дор жагсаалын бага дарга нарын дурсамж уулзалтыг 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 11.00-15.30 цагт зохион байгуулав. 4 цаг 30 минут	13500000
11	2019.07.10	2013.01.18 A/33	Жагсаалт батлах, төлбөрөөс чөлөөлөх	Тулгар төрийн 2228, Их Монгол улс байгуулагдсаны 813, ардын хувьсгалын 98 жилийн ой баяр наадмын концертыг 2019 оны 07 дугаар сарын 10-ны өдөр 15.00-17.30, 18.00-20.30 цагуудад 2 удаа зохион байгуулав. 5 цаг Хяналт сургуулилтын цаг 40 цаг	35000000
12	2019.07.20	2013.01.18 A/33	Жагсаалт батлах, төлбөрөөс чөлөөлөх	Монгол Хятад улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан Бээжингийн соёлын өдрүүдийн концертыг 2019 оны 07 дугаар 20-ны өдөр 18.00- 20.00 цагт зохион байгуулав. 2 цаг Сургуулилтын цаг 18/VII –нд 11 цаг, 19/VII –нд 9 цаг нийт 20 цаг	16000000
13	2019.08.27	2013.01.18 A/33	Жагсаалт батлах, төлбөрөөс чөлөөлөх	Халх голын ялалтын 80 жилийн ойн хүрээнд ОХУ-ын Александровын нэрэмжит цэргийн дуу бүжгийн чуулгын тоглолтыг 2019 оны 08 дугаар сарын 27-ны өдөр 19.00-21.00 цагт зохион байгуулав. 2 цаг Сургууллт 7 цаг	9500000
14	2019.10.25	2013.01.18 A/33	Жагсаалт батлах, төлбөрөөс чөлөөлөх	Д.Лувсаншаравын нэрэмжит хүүхдийн найрал дууны наадам 2019 оны 10 дугаар сарын 25-ны 15.00-17.00 цагт зохион байгуулав. 2 цаг, сургууллт 10 цаг	11000000
15	2019.10.28	2013.01.18 A/33	Жагсаалт батлах, төлбөрөөс чөлөөлөх	Улаанбаатар хотын 380 жилийн ойн концертыг 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 14.00-17.00, 18.00-21.00 цагт зохион байгуулав. 6 цаг Сургууллт 24 цаг	30000000
16	2019.10.31	2013.01.18 A/33	Жагсаалт батлах, төлбөрөөс чөлөөлөх	Ерөнхий сайдын “Чиний боловсрол Монголын ирээдүй” оюутны чуулган 2019 оны 10 дугаар сарын 13.00-16.00 цагт зохион байгуулав. 3 цаг	9000000
	ДҮН				295.000.000

Жич: 2019 онд Нийслэлийн Засаг даргын захирамжаар 107 цагийн бэлтгэл сургууллт хийж, 72 цагийн тоглолт арга хэмжээ зохион байгуулав.

2.2.2. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тогтоол шийдвэрийн хэрэгжилт.

Засгийн газраас 2018 онд баталсан “Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах” 258 тогтоол, нийслэлээс 2018 оныг “Хариуцлагын жил” болгож, хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллагын ажилд тогтоосон сахилга хариуцлага, дэг журмыг 2019 оны үйл ажиллагаандаа хэвшил болгон ажиллаж ирлээ. Үүнд:

1. Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтийг ханган ажиллах, холбогдох заалтыг байгууллагын дотоод журамд тусгаж хэрэгжүүлж байна. Цаашид Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 1.2 дах заалтыг үндэслэн байгууллагын чиг үүрэг, үйлчилгээний онцлогийг харгалзан албан хаагчдын ёс зүйн дүрмийг боловсруулан гаргаж, мөрдөж ажиллах болно.
2. Байгууллагын үйл ажиллагаанд тогтоосон дэг журмыг зөрчиж, ажилдаа хариуцлагагүй хандсан, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, ажлын байрны мэргэжлийн шаардлагыг хангаж ажиллаагүй, 2 албан тушаалтанд зохих хууль, журмын дагуу сахилгын зөрчил ногдуулж, арга хэмжээ авлаа.
3. Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/417 дугаар захирамжийг үндэслэн байгууллагын үйл ажиллагааны өвөрмөц онцлог, бодит шаардлагыг харгалзан албан хаагчдын ажиллах цагийн хуваарийг шинэчлэн тогтоож, баримтлан ажиллаж байна.
4. Албан хаагчдын сахилга, үйл ажиллагааны аюулгүй байдлыг 32 камераар байнга хянаж, албан хаагчдын ажилд ирсэн, явсан цагийг хурууны хээгээр бүртгэх төхөөрөмжийг 286000 төгрөгөөр худалдан авч үйл ажиллагаандаа хэвшүүлж байна.
5. Захирал, ахлах нягтлан бодогч нар хувийн ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг хуулийн дагуу гаргаж өгсөн.
6. Шилэн дансны хуулийн дагуу 2019 оны жилийн санхүүгийн мэдээллүүдийг цаг хугацаанд нь шилэн дансны нэгдсэн системд оруулж ажиллалаа. Энд батлагдсан төсөв сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн харьцуулалт, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого зарлагын гүйлгээ зэрэг багтаж байгаа юм. Мөн шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлын хариуцан ажиллаж, тайланг цаг тухайд нь Сангийн яаманд илгээж байна. 2019 оны байдлаар нийт 134 шилэн дансны мэдээллийг цаг тухай бүрд нь байршууллаа.
7. “Нийслэлийн хүн амд соёл урлагаар үйлчлэх үйлчилгээний нэр төрлийг олшруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд нийслэл, хөдөө орон нутгийн байгууллагуудаас ирүүлсэн санал, хүсэлт, уран бүтээлчид, урлагийн байгууллага, иргэдийн тоглолт, арга хэмжээний захиалгыг урьдчилан авч, нийт 198 тоглолт, арга хэмжээг зохион байгууллаа.
8. Архивын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 150 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн Улсын үзлэг явуулах төв комиссын бүрэлдэхүүн, батлах тухай 46 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн Нийслэлийн хэмжээнд Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн Улсын үзлэг зохион байгуулах тухай А/518 дугаар захирамжийн хүрээнд Дүүргийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн “Дүүргийн хэмжээнд Төрийн байгууллагын

ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн Улсын үзлэг зохион байгуулах тухай” А/246 дугаар захирамжийн дагуу архивын улсын үзлэгт бэлтгэж ажиллан **нийт дүнгээр 90.4 % (А) дүнтэй үнэлэгдлээ.**

9. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж ажилласан. 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитыг нийслэл дэх Төрийн аудитын газраар хийлгэж **“Санхүүгийн тайлангаа холбогдох хууль, санхүүгийн тайлангийн олон улсын стандарт, нягтлан болох бүртгэлийн олон улсын стандарт, түүнд нийцүүлсэн холбогдох заавар журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн, санхүүгийн зөрчилгүй”** гэсэн дүгнэлт авсан.

2.2.3. Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн асуудлаар өгсөн үүрэг даалгаварын хэрэгжилт. Тухайлбал:


1. 2019 оны 02 дугаар сарын 21-ний “Аян зохион байгуулах тухай” А/61 дүгээр захирамжийн хүрээнд 2019 оны 03 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулсан эргэн тойрны цэвэрлэгээ хийж 1 машин хог ачуулан цэвэрлэгээний ажлыг фото зургаар баримтжуулан urnaa_husle@yahoo.com хаягаар,
2. Сүхбаатар дүүргийн 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах тухай А/265 дугаар захирамжийн дагуу 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдөр байгууллагын эргэн тойрны хана, багана, хаяавчуудыг угааж, зарлал сурталчилгааны хуудсыг хуулж цэвэрлэн, ногоон байгууламжийн зэрлэг хөл ургамлыг цэвэрлэн нийт 1300 м² талбайг цэвэрлэсэн. Цэвэрлэгээний ажлуудыг зургаар баталгаажуулан sbdnaah@yahoo.com хаягаар мэдээгээ явууллаа.





3. Ерөнхийлөгчийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 2010 оны 63 дугаар зарлигийг хэрэгжүүлэх арга хэмжээнд оролцож ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д заасны дагуу мөнгөн хандив **260000** төгрөгийг Нийслэлийн төрийн сан дахь Нийслэлийн Байгал Орчны газрын 100200000907 тоот дансанд шилжүүлсэн болно.
4. Монгол Улсын ерөнхийлөгчийн 2010 оны Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх зарлигийн дагуу байгууллагын Насанд хүрэгчдийн бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг нийт албан хаагчдын 20-с илүү хувьд авсан. Насны ангилалаар авч үзвэл 22-56 хүртэлх насныхан оролцож алба тус бүрээс тэгш оролцоог хангаж оролцууллаа.

Албан хаагчид 7 төрлийн сорилыг амжилттай давж хүн тус бүрийн авсан үнэлгээг Биеийн Тамир Спортын газрын <http://soril.sport.gov.mn/soril/>-д бүртгүүлсэн. Тухайлбал: Сорилд Санхүүжилт менежментийн албаны Хонгор, Бат-Эрдэнэ, Баянзул, Д.Бямбажав, Уран бүтээл техникийн албаны Наранцэцэг, Болдбаяр, Батнягт, Батзаяа, Өлзийжаргал, Маркетинг менежментийн албаны Амартүвшин, Мөнхтогтох, Инженер техникийн албаны Мөнхбаяр, Гэрэлээ, Майбаяр нар оролцлоо.



Сорил. 2019 оны 4 сарын 24-ны өдөр



5. “Улаанбаатар марафон-2019” олон улсын гүйлтийн уралдааныг зохион байгуулах ажлын хэсэгт захирал Б.Байгалмаа оролцож, оролцогч хүмүүсийн болон гадаадын зочид, гүйгчдийн хувцас өлгөх, хадгалах, халуун цай, ус ундаагаар үйлчлэх цэгүүдийг Өргөөнд ажиллууллаа.

2.2.4. Үйл ажиллагааны гүйцэтгэл сайжруулах дараах ажлуудыг хэрэгжүүллээ. Үүнд:


www.edoc.ulaanbaatar.mn-ийг ашиглан:

Ирсэн албан бичиг: Тайлант хугацаанд нийт 188 албан бичиг ирснээс 61 хариутай бичгийг хүлээн авч тухай бүрд нь холбогдох албан тушаалтанд танилцуулж хугацаатай албан бичгийн хариуг хугацаанд нь явуулсан.

Явуулсан албан бичиг: Нийслэлийн засаг даргын тамгын газарт 38 бичиг, бусад байгууллага ААН-д 62 албан бичиг, нийт 110 албан бичиг явуулсан.

Энэ онд тус системийг ашигласнаар 757 хуудас цаас хэмнэж ажиллаа.

www.erp.ulaanbaatar.mn-ийг ашиглан:



Цаг бүртгэлийн систем:

Хурууны хээний бүртгэлийн Zkteco UF-200 төхөөрөмжийг байршуулан бүх ажилчдын цаг бүртгэлийн хяналтыг тус системээр байнга хийн ажиллаж байна.

Өргөдөл гомдол: Ажилтнуудаас хандсан өргөдөл гомдол нийт -ийг хүлээн авснаас ээлжийн амралттай холбоотой , ажлын байр солих асуудлаар 2, ажилд орох хүсэлт 21 , ажлаас чөлөөлөгдөх хүсэлт 15 , бусад асуудлаар хандсан.

Тушаал: “Б” тушаал 91 гарснаас үүнээс ажлаас чөлөөлөх 15, ажилд авах 21, шилжүүлэн ажиллуулах тушаал 4, буцалтгүй тусламж олгох 7, ээлжийн амралт эдлүүлэх 24 тушаал гарсан байна. “А” тушаал үйл ажиллагаатай холбоотой 18 гаргаж хэрэгжүүлсэн байна.

/www.arch.ulaanbaatar.mn/-ийг ашиглан:

2018 оны захирамжлалын бичгүүдийг байгууллагын архивын системд сканнердаж оруулав. 2019 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гарган байгууллагын ББНШК-оор хэлэлцүүлэн батлуулав. 2018 онд батлуулсан устгах 11 хэргийн 96 хадгаламжийн нэгжүүдийг актын дагуу устгаж, Нийслэлийн Архивын газарт илтгэх хуудсаар хүргүүлэв. 2013 оноос хойших захирамжлалын баримт бичгүүдийг нягтлан шалгаж дутуу хавсралтуудыг нөхөн сэргээж НАГ-тай байнгын нягт холбоотой ажиллаж байна.

Гурав. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн:

3.1. Хүн амд үзүүлэх соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хийсэн ажил, үр дүн.

Өргөө нь байгууллагын дүрмээр хүлээсэн “Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан соёл урлагийн бодлого зорилтыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, “Нийслэлийн хүн амд соёл

урлагаар үйлчлэх үйлчилгээний нэр төрлийг олшруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх” үүргээ амжилттай зохион байгуулж, хэрэгжүүлж ирлээ.

Тус зорилтын хүрээнд нийслэл, хөдөө орон нутгийн байгууллагуудаас ирүүлсэн санал, хүсэлт, уран бүтээлчид, урлагийн байгууллага, иргэдийн тоглолт, арга хэмжээний захиалгыг урьдчилан авч, сар бүр зохион байгуулах ажлын график гарган ажиллаж, давхардсан тоогоор **198** удаагийн соёл урлагийн үзвэр, үйлчилгээ, хурал зөвлөгөөнд тайз, гэрэл, дууны тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж, **200** мянга гаруй хүнд соёлч боловсон үйлчиллээ. Үүнд:

-Шинэ үе продакшны “Шилдгийн шилдэг” хошин шоу тоглолт,

-Herbalife сургалт,

-МҮХАҮТ-ын ХХ их хурал,

-Морин хуур наадам,

-Нийслэлийн удирдах ажилтны өргөтгөсөн шуурхай зөвлөгөөн,

-Эмоци продакшны “Миний ээж атаман” хошин шоу тоглолт,

-Их хотын бүсгүйчүүд, Март-8 арга хэмжээ,

-Одонтой ээжүүд,

-АПУ ХХК-ийн “Ерөөл өргөх ёслол” хурал, арга хэмжээ,

-Нийслэлийн цэргийн баяр,

Сонгинохайрхан дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө,

-Наурызын баяр,

-Хөрөнгө оруулагчдын чуулганд оролцогчдод зориулсан концерт,

-Монголын багш нарын VII их хурлын төлөөлөгчдөд зориулсан концерт,

-Хөвсгөлийн жүжигчин, дуучин Галаагийн тайлан тоглолт,

-“Хараат бус ёсзүй” форум,

-Орос III сургуулийн төгсөлтийн уулзалт,

-СХД-ийн 42 дугаар сургуулийн 50 жилийн ойн концерт,

-Шинэ үе продакшны “Буйд нутаг” жүжиг,

-“Саран ээж” нийгэмлэгийн хурал,

-СУИС-ийн диплом гардуулах ажиллагаа,

-Уртын дууны тайлбарт лекц,

-Монгол банкны 95 жилийн ойн баярын концерт,

-МУЗН-ийн хүмүүнлэгийн үйлсийг алдаршуулах ёслолын үйл ажиллагаа,

-Олон улсын ардын урлагийн их наадам,

-Залуучуудын чуулга уулзалт,

-Монгол Коосен технологийн коллежийн төгсөлтийн ёслолын арга хэмжээ,

-Ардчилсан намын хурал,

-Онцгой байдлын ерөнхий газрын хурал,

-Ерөнхий сайдын ивээл дор цэргийн бага дарга, жагсаалын дарга нарын дурсамж уулзалт,

-Худалдаа хөгжлийн банкны хурал

-Тулгар төрийн 2228, Их Монгол улс байгуулагдсаны 813 жил, Ардын хувьсгалын 98 жил, Үндэсний их баяр наадмын “МИНИЙ ЭХ ОРОН” хүндэтгэлийн тоглолт, Монгол Хятад улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойн хүрээнд

-Бээжин хотын соёлын өдрүүд

-Шаолины үзүүлбэр тоглолт

-ӨМӨЗО-ны уран бүтээлчдийн тоглолт

Халх голын 80 жилийн ойн хүрээнд

-Александровын нэрэмжит цэргийн чуулгын тоглолт

-И.Моисеевын нэрэмжит ардын бүжгийн чуулгын тоглолт

- Эмоци продакшны “Монгол гайхамшиг” тоглолт

- УБДС ТӨХК-ийн 60 жилийн ойн арга хэмжээ
- Нийслэлийн ахмадын баярын концерт
- ШУТИС –ийн 60 жилийн ойн баярын арга хэмжээ
- Урлагт 40 жил тоглолт
- Шинэ үе продакшны “Жаргалтай байх нь чухал” хошин шоу тоглолт
- Дорноговь аймгийн соёлын өдрүүдийн хүндэтгэлийн тоглолт
- Бүжихүйн гайхамшиг
- Геологийн салбар үүсч хөгжсөний 80 жилийн ойн концерт
- “Эрт эдүгээ ирээдүйн Улаанбаатар” үзэсгэлэнгийн нээлт Монгол улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин Д.Лувсаншаравын нэрэмжит хүүхдийн найрал дууны наадам
- Улаанбаатар хот үүсч байгуулагдсаны 380 жилийн ойн хүндэтгэлийн тоглолт --
- Ерөнхий сайдын “Чиний боловсрол Монголын ирээдүй ” лекц
- Оюутны чуулган
- Нэг хот нэг стандарт анхдугаар зөвлөгөөн
- ШУТИС-ийн оюутны чуулган
- УСУГ-ын 60 жилийн ойн баярын хуоал, концерт
- Төрийн банкны 10 жилийн ойн баярын хурал концерт
- Дуучин Чулуунбаатарын концерт
- Гоёл -2020 наадам
- Ардчилсан намын 30 жилийн рйн баярын арга хэмжээ
- Эмэгтэйчүүдийн чуулга уулзалт
- Цагдаагийн тайлангийн хурал
- ОБЕГ-ын оны эцсийн тайлангийн хурал

зэрэг тоглолт арга хэмжээний үеийн танхим, тайз, жүжигчдийн өрөө, ажлын байрны цэвэрлэгээ үйлчилгээ, техник тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, ажлын бэлэн байдлыг сайтар ханган, байгууллага уран бүтээлчидтэй гэрээ байгуулан төлбөрийг цаг хугацаанд нь барагдуулан мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулж уран бүтээлчид, найруулагч нараас өндөр үнэлэлт авч ажиллалаа.

Тулгар төр байгуулагдсаны 2228, Их монгол улс байгуулагдсаны 813, Ардын хувьсгалын 98 жилийн ой Төрийн хүндэтгэлийн концертын бэлтгэл сургуулилтыг 6 дугаар сарын 28-ны өдөр 13 цагаас концертын зохион байгуулагчид ирж тайз, техник тоног төхөөрөмжтэй танилцав.

Энэ оны 7 дугаар сарын 01-ний 10.00-14.00, 15.00-18.00 цагт дуурийн дуучид, симфони найрал хөгжим, 7 дугаар сарын 02-ны 10.00-18.00 цагт бүх дуучид, хөгжимчид, жүжигчид, 7 дугаар сарын 04-ний 14.00-18.00 цагт концертын хяналт, 7 дугаар сарын 06 -ны 10.00-14.00, 15.00-18.00 цагт дуурийн дуучид, симфони найрал хөгжмийн сургуулилт, 7 дугаар сарын 07-ны 09.00-18.00 цагт жүжигчид, 07 дугаар сарын 08-ны 14.00-17.00 цагт нэгдсэн сургуулилт хийж, 7 дугаар сарын 09-ний өдрийн 11 цагаас 07 дугаар сарын 10-ны өглөөний 09.00 цаг хүртэл шинээр уран сайхны гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжүүдийг шинээр суурилуулан ажилд орууллаа. 07 дугаар сарын 10-ны өдөр 15.00,18.00 цагуудаас 2 удаа тоглолтыг зохион байгуулж нийслэлчүүддээ толилууллаа.

Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин Д. Лувсаншаравын нэрэмжит хүүхдийн найрал дууны гала концертын бэлтгэл сургуулилтыг 10 дугаар сарын 24-ны 09.00-17.00 цагт, 25-ны 08.00-13.00 цагуудад тус тус хийж нөхцөл бололцоогоор ханган ажиллаж 10 дугаар сарын 25-ны 14.00 цагаас толилууллаа.

Нийслэл Улаанбаатар хотын 380 жилийн ойн хүндэтгэлийн концертыг 10 дугаар сарын 28-ний 15.00, 18.00 цагуудаас нийслэлчүүддээ толилуулж

ажиллалаа. Хүндэтгэлийн тоглолтыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтарч, мэргэжлийн урлагийн байгууллагуудтай төлөвлөгөөний дагуу хамтран ажиллаж чанартай тоглолт уран бүтээлийг нийслэлийн 380 жилийн ойгоор үзэгч түмэндээ хүргэлээ. Тоглолтонд: Үндэсний урлагийн их театр, Дуурь бүжгийн эрдмийн театр, Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга, Монгол Улсын Филармонийн “Морин Хуурын чуулга”, “Симфони Найрал” хөгжим, “Баянмонгол” чуулга, Нийслэлийн “Улаанбаатар” чуулга, Монгол Улсын Консерватори, Монголын Хүүхдийн Ордон зэрэг мэргэжлийн урлагийн байгууллагын зургаан оркестр, найрал дуучид, бүжигчид, үе үеийн урлагийн алдартнууд тэргүүтэй 800 гаруй уран бүтээлчид оролцлоо.













Хүндэтгэлийн концертыг Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх болон төр, засгийн түшээд, Нийслэлийн ИТХ-ын дарга Р.Дагва, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан тэргүүтэй нийслэлийн үе үеийн удирдлагууд, нийслэлийн хүндэт иргэд, гадаадын зочид төлөөлөгчид үзэж соёрхлоо.

Концерт маань нийслэлийн удирдлагаас сайн найруулгатай боллоо гэсэн сайшаалын үг сонссонд бид баяртай байна. Энэ концертыг хийхэд Соёлын төв өргөөний нийт хамт олон сэтгэл зүрхээрээ гар нийлэн хамтарч нэгэн сэтгэлээр ажиллалаа. Хүндэтгэлийн концертын ерөнхий найруулагчаар Төрийн соёрхолт, Монгол Улсын Урлагийн Гавьяат зүтгэлтэн Сэвжидийн Сүхбаатар, Концертын захирлаар Нийслэлийн Соёлын Төв Өргөөний захирал, Монгол Улсын Урлагийн Гавьяат зүтгэлтэн Бадамын Байгалмаа, Ерөнхий зураачаар Дуурь Бүжгийн Эрдмийн театрын ерөнхий зураач, Монгол Улсын Урлагийн Гавьяат зүтгэлтэн Гунгаасүхийн Ганбаатар, Концертын хөтлөгчөөр СГЗ Д.Цоодол, Ч.Ичинхорлоо туслах найруулагчаар Нийслэлийн Соёлын Төв өргөөний Уран бүтээл техникийн албаны дарга Д.Баянзул, Үндэсний Урлагийн Их Театрын бүжиг дэглээч МУСТА Х.Хашхүү нар ажиллалаа.





3.2. Байгуулагын менежментийг боловсронгуй болгох, өмчийн ашиглалтыг сайжруулах талаар:

Өргөө нь байгууллагын дүрмээр хүлээсэн “нийслэлийн өмчийн барилга байгууламж, эд хөрөнгийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад түрээслүүлэх, соёл урлагийн арга хэмжээнд төлбөртэй ашиглуулах зорилт”-оо хангалттай хэрэгжүүлж ажиллаж байна. Тухайлбал:

Өргөөний цогцолборын дулаан, цахилгаан, ус хангамжийн болон хог хаягдал, лифтийн үйлчилгээний аж ахуйн гэрээ улиралд байгуулж төлбөрийг цаг хугацаанд нь барагдуулж найдвартай ажиллагааг хангаж, өвлийн халаалтын дулаан, сантехник, цахилгаан, усан хангамжийн ямар нэгэн доголдол, аваар осолгүй ажиллалаа.

Цахилгаан эрчим хүчний гэрээг 2024 оны 5 дугаар сарын 23-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатай, дулааны эрчим хүчийг худалдах, худалдан авах гэрээг 2028 оны 10 дугаар сарын 01 хүртэл 10 жилийн хугацаатай тус тус сунгалаа.


Түрээслэгч байгууллагуудаас 2019 онд ирсэн санал хүсэлтийг хугацаанд нь барагдуулж, 4 дүгээр сарын 1-нд салхивч, 5 дугаар сарын 1-нд халаалтаа хааж, засварын ажлуудыг графикийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Өвлийн бэлтгэлийг хангаж ажиллах үүднээс цонх хаалга дулаалах, гаднаас орох хаалгануудын шатанд хивсэнцэр наах, цахилгааны болон дулааны төв узельд их цэвэрлэгээ хийх, гэрэлтүүлгийг шинэчлэх, ялтсан бойлеруудыг угаах, хэрэглээний хүйтэн усны насос, дулаан, цахилгаан хангамжийн тоолуур шинэчлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Үзэгчдийн их танхим, тайзны зарим хэсэг, Театрын музей, Уран зургийн галерей, Нийслэл дэхь төрийн аудит, Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл зэрэг байгууллагуудын борооны ус их хэмжээгээр нэвтэрч байсан дээврийг хэсэгчлэн хар цаас нааж засварлалаа. “Б” хэсгийн 1 дүгээр давхрын коридорын гэрэлтүүлгийг шинээр суурилуулсан.

Тулгар төрийн 2228, Их монгол улс байгуулагдсаны 813 жил, Ардын хувьсгалын 98 жилийн ойн баярын “МИНИЙ ЭХ ОРОН” хүндэтгэлийн тоглолтын өмнө стандартын дагуу үйлдвэрлэгдэж, чанарын шаардлага хангасан Color Image, Showtec, ETC, Fine, Net.Do, Ultralite, Senheiser, AKG брендийн уран сайхны гэрэлтүүлэг, дууны тоног төхөөрөмжүүдийг 120 сая төгрөгийн нийслэлийн хөрөнгө оруулалтаар, Dynacord, Yamaha брендийн дууны тоног төхөөрөмжүүдийг Үндэсний баяр наадмыг зохион байгуулах хорооны төсвийн 364 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус шинэчилж суурилуулан хөрөнгөд бүртгэж авлаа.

Гэрэлтүүлгийн тоног төхөөрөмж шинэчлэл





Дуу дуугаралтын тоног төхөөрөмж шинэчлэл





Нийслэлийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/296 дугаар захирамжаар манай байрны дээврийн их засварын ажлыг нийслэлийн хөрөнгө оруулалт 1 тэрбум 200 сая төгрөгөөр хийхээр шийдвэрлэсэн.

“А”, “Б”, “Г” хэсгийн барилгын дээврийн их засварын ажлын зураг төсөл боловсруулах даалгаварт саналаа оруулж Нийслэлийн Хөрөнгө Оруулалтын газарт 6 дугаар сард хүргүүлсэн.


Нийслэлийн Худалдан Авах Ажиллагааны газраас зарласан сонгон шалгаруулалтанд СНТ Групп ХХКомпани дээврийн засварын ажлуудыг хийж гүйцэтгэхээр шалгарч 2019 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс засварын ажлуудыг эхэлсэн.

Манай байгууллагын зүгээс уг засварын ажилд ихээхэн анхаарч хяналт тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүр нь засч залруулах чиглэлээр ажиллах хүнийг томилж ажиллуулав. Засварын ажил хийх хугацаанд засварын ажил хийж гүйцэтгэхтэй холбогдсон ажил төрлийн уулзалт яриаг Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар, засварын ажил гүйцэтгэх компанийн холбогдох инженер техникийн ажилтан нартай байнга зөвлөлдөж ажилласан болно.

Байгууллагын зүгээс засварын ажил хийх ажилчдад зориулж хувцас солих, ажлын багаж хэрэгсэл хадгалах тусгай өрөө гарган өгч, ус, цахилгаанаар найдвартай хангаж ажиллав. Засварын ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓ Бороо цасны ус урсах гадаргуугын налууг тохируулах зорилгоор хуучин хар цаасан дээврийг хуулж зориулалтын зуурмагаар тохируулав.
- ✓ Ашиглалтын явцад шинээр хийж буй дээврийн хучилтын материалын доорхи гадаргуунд их хэмжээгээр агаар хуримтлагдаж болзошгүй байдлыг харгалзан агаар амьсгуулагч хэрэгсэл 20 ширхэгийг шинээр байрлуулав.
- ✓ Барилгын дотроос дээвэр гадагшаа гарч буй бохир усны яндан хоолойд тусгай нэмэлт хоолойг сэнсний хамт нэмж угсруулж хийлгүүлэв.
- ✓ Дээврийн ус зайлуулах шугам хоолой 5 хэсэг газарт бөглөрснийг арилгаж зарим гэмтсэн шугам хоолойг засварлав.
- ✓ Барилгын дээврийн бороо, цасны ус зайлуулах хоолойн амсрын битүүмжлэлийг шинээр гүйцэтгэж 41 ширхэг трапын шүүлтүүр тагийг хийлгүүлэв.
- ✓ Борооны ус зайлуулах шифр дээвэр, төмөр дээврийг шинэчлэн хийлгэв.
- ✓ Уран зургийн галерейн барилгын дээвэр дээрхи байгалийн 12 ширхэг гэрэлтүүлгийг шинээр сайжруулан хийлгүүлэв.
- ✓ 2008 оны 7 дугаар сарын 01-ний өдөр болсон үймээний үед барилга гал түймэрт өртөж барилгын гадна талын гэрэлтүүлгийн кабель өртөгдсөнөөс болж уг гэрэлтүүлгийг сэргээн засварлах хөрөнгө дутагдалтай байв. Уг гэрэлтүүлгийн засварын ажлыг иж бүрэн хийлгэж 120 ширхэг гэрэлтүүлгийг удирдлагын самбарын хамт шинэчлэн суурилуулж 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдөр ажилтай болголоо.
- ✓ Барилгын парapedны хөнгөн цагаан хавтан төмөр суларч унасныг нөхөн хийж уг парapedны бүрэн бүтэн байдлыг хангуулах арга хэмжээг авахуулав.
- ✓ Барилгын дотроос гадагш гарах тоосгон дөрвөлжин сувгийн зарим хэсэгт тоосгон өрлөг нурж унасан хэсгийг шинэчлэн засварлуулав.

Дээврийн засварын ажил өмнө ба дараа нь



Ажиллагсдын эрүүл зөв хооллох нөхцлийг бүрдүүлэх зорилгоор “А” хэсгийн 306,307 тоот өрөөнүүдийг цайны өрөөний зориулалтаар засварлаж, тохижууллаа. Үүнд: хана, таазыг хусаж цэвэрлэх, хүрээ булан хийх, фүжи шингэн цаас обой таазанд нааж, хананд корунд түрхэж удаан эдэлгээтэй чулуун хана хийв. Шинээр цахилгаан зуух, агаар шүүгч, духовка, хөргөгч, хөлдөөгч, тавилга худалдан авч тохижууллаа.

Засварын өмнө ба дараа



Мөн “Г” хэсгийн 5 дугаар давхрын Нийслэлийн Соёл урлагийн газрын 1 өрөөний тааз эмульсдэж, хананд гоёлын хавтан, хүрээ нааж, хаалга шинэчлэн суулгав.

3.3 Төсвийн орлогын бүрдүүлэлт, төвлөрүүлэлтийн тухай.

Манай байгууллага түрээсийн буюу үзвэр үйлчилгээ, арга хэмжээний орлогоор үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлж, батлагдсан төсөв, үр дүнгийн гэрээний хүрээнд зардал гарган, төсвийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулж, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, хуулийн хугацаанд тайлагнаж ирлээ.

Өргөө нь НӨХГ-тай өмч эзэмшлийн гэрээ байгуулан ажиллаж байна. “Б”, “Г” хэсгийн ажлын байрыг НИТХ-ын тэргүүлэгчдийн 2010 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан түрээсийн төлбөрийн жишиг үнийг баримтлан түрээсийн гэрээ байгуулж, НӨХГ-аар хянуулж, баталгаажуулж, хэрэгжилтийг хангаж, орлогыг бүрдүүлж ажиллаж байна.


2019 онд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нийлсэн **34** түрээслэгчтэй түрээсийн гэрээ, тоглолт арга хэмжээнд их танхимыг ашиглуулсны **57** түрээсийн гэрээг тус тус байгуулан гэрээний биелэлтийг хангуулж, НИТХ-аас баталсан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааны зардлаа санхүүжүүлж, мөн Нийслэлийн өмчийн газартай байгуулсан эд хөрөнгийн түрээсийн 010101 тоот гэрээний дагуу нийслэлийн төсөвт **332** сая төгрөг төвлөрүүлж, төсвийн сахилгыг сахиж ажиллалаа.

Нийслэлийн Соёлын Төв Өргөөний 2000-2019 онд бүрдүүлсэн орлого, төсөвт төвлөрүүлсэн, үйл ажиллагааг санхүүжүүлсэн мөнгөн хөрөнгийн тооцоо

Д/Д	Он	Нийт бүрдүүлсэн орлого	Зарлага		Захирамж	Төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө	Хувь
			Зардал санхүүжүүлэх	Төвлөрүүлсэн орлого			
1	2000	565,261.6	376,666.6	188,595.0	-	171,419.8	110.0
2	2001	789,100.5	576,733.0	212,367.5	10,500.0	176,391.8	120.4
3	2002	730,734.7	544,884.7	185,850.0	16,950.0	185,524.8	100.2
4	2003	704,033.9	496,433.9	207,600.0	43,000.0	206,400.0	100.6
5	2004	983,306.7	708,514.7	274,792.0	24,050.0	210,993.7	130.2
6	2005	1,120,315.8	856,616.4	263,699.4	87,150.0	263,699.4	100.0
7	2006	1,287,005.2	929,403.2	357,602.0	98,350.0	345,291.8	103.6
8	2007	1,513,564.6	1,050,507.7	463,056.9	6,225.0	375,009.6	123.5
9	2008	1,464,915.5	1,100,407.2	364,508.3	50,750.0	364,449.2	100.0
10	2009	1,267,699.4	1,017,699.4	250,000.0	74,400.0	249,340.6	100.3
11	2010	1,388,227.8	1,108,227.8	280,000.0	88,750.0	280,006.2	100.0
12	2011	1,552,116.9	1,253,688.1	298,428.8	78,575.0	298,428.8	100.0
13	2012	1,694,306.2	1,244,306.2	450,000.0	44,162.5	304,031.9	148.0
14	2013	1,637,720.6	1,257,720.6	380,000.0	147,500.0	377,545.2	100.7
15	2014	1,659,664.5	1,252,664.5	407,000.0	104,500.0	406,027.6	100.2
16	2015	1,580,607.1	1,157,707.1	422,900.0	89,500.0	422,000.0	100.2
17	2016	1,564,740.4	1,202,740.4	362,000.0	102,000.0	361,093.7	100.3
18	2017	1,476,899.4	1,115,651.6	361,247.8	115,252.2	361,247.8	100.3
19	2018	1,396,156.1	1,070,462.3	325,693.7	168,500.0	352,339.1	100.3
20	2019	1,651,495.6	1,319,455.6	332,000.0	295,000.0	331,200.0	100.3
		26,027,872.5	19,640,491.0	6,387,341.4	1,645,114.7	6,042,440.8	

Дээрх хүснэгтээс үзэхэд Өргөө нийслэлийн өмчид шилжиж ирсэн 2000 оноос 2019 онд түрээсээс, их танхим ашиглуулснаас **26.0** тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлж, байгууллагын үйл ажиллагааны зардлыг **19.6** тэрбум төгрөгөөр санхүүжүүлж, **6.4** тэрбум төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлж, жил бүрийн түрээсийн орлогын бүрдүүлэлтийг **100-гаас дээш хувиар** биелүүлсэн үр дүнг үзүүлж ирлээ.

Нийслэлийн Соёлын Төв Өргөөний 2000-2019 онд бүрдүүлсэн орлого, төсөвт төвлөрүүлсэн, үйл ажиллагааг санхүүжүүлсэн мөнгөн хөрөнгийн тооцоог графикаар харуулвал:



Мөн Нийслэлийн Төрийн сангаас Монгол Улсын 2018 оны 302 дугаар тушаалаар зохион байгуулагдсан нягтлан бодох бүртгэлийн улсын үзлэгийн түүвэр шалгалтад хамрагдаж, амжилттай дүн үзүүлээ.

3.4. Байгууллагын хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар дараах ажлуудыг хийлээ. Үүнд:

Хүнийг хөгжүүлэх тусам чадвар нь өсөж, боловсорч хөгжихийн хэрээр сэтгэж, сэтгэхийнхээ хэрээр бүтээдэг онцлогтойгоороо бусад нөөцүүдээс давуу талтай юм. **Өөрөөр хэлбэл**, төрийн байгууллагын зорилт, чиг үүргийг цомхон, мэдлэг чадвартай, гадаад, дотоод орчны өөрчлөлтөд уян хатан зохицож чаддаг, төрийн албан хаагчдаар гүйцэтгүүлж, иргэдэд ойр, **хэрэгцээг** нь хангасан чанартай төрийн үйлчилгээг үзүүлэх үүрэг, хариуцлагын тогтолцоог бий болгох, улмаар байгууллагаас олон талт, өргөн цар хүрээтэй мэдлэг чадвар бүхий хүний нөөцтэй байх, хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлж байхыг **шаарддаг**.

3.4.1. Иймд Өргөөний захиргааны зөвлөлийн хуралдаанаас байгууллагын зорилт, чиг үүргийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай явуулахад тоо, чанарын шаардлага хангахуйц хүний нөөцийг бүрдүүлэх, “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг баталж, захиргааны зөвлөлийн гишүүдэд эрхэлсэн ажилтай нь уялдуулан албан хаагчдын эрүүл мэнд, ажлын байрны нөхцөл сайжруулах, техник хэрэгсэлээр хангах, сургах, мэргэшүүлэх, үйлчилгээ, харилцааны соёл эзэмшүүлэх, хүний нөөцийн мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах, зэрэг олон ажлыг даалгаж, хэрэгжүүллээ.

Хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар жилийн ажлын төлөвлөгөөнд тусгасан зорилтын биелэлтийг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 10 дүгээр хавсралтын дагуу тооцож гаргалаа.

ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ, ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ ТАЛААР БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ						
Зорилт	№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Зурилтот түвшин (Тоо хэмжээ, хувь)	Хүрсэн түвшин (Хэрэгжилтийн хувь, тоо хэмжээ)	Заруулсан хөрөнгө, эх үүсвэр гүйцэтгээр (Мян.төг)
1. Хүний нөөцийг чадавхжуулах	1	Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт	Дотоод сургалтын тоо	5-аас дээш	9	
			Албан хаагчдын хамрагдсан байдал/ажлын байрны сургалт	80%	100%	
			Гадаад сургалтын тоо /туршлага судалсан/	0		
			Албан хаагчдын хамрагдсан байдал	2%	100%	
2	Мэргэшсэн, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх	3 болон түүнээс дээш жил ажилласан мэргэшсэн боловсон хүчний үзүүлэлт	70%-аас дээш	89%		
Хэсгийн дундаж:						
2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	3	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	шагнал, урамшуулалд хамрагдсан албан хаагчдын тоо	45	100%	38975.4
			Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварын болон хавсран ажилласны нэмэгдэл,	21	100%	35487.7
	4	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга	Сэтгэл ханамж 80%	100%	64013.4
			Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх	45	100%	
	5	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг	жилд 1 удаа	1 удаа	28
Албан хаагчдын хамрагдалт			100%	100%		
Хэсгийн дундаж:						
Үнэлгээний дундаж хувь:						100%

Хүснэгтээрх зарим ажлыг тодруулж үзвэл:

Сургалтын чиглэлээр: “Харанга” хамтлагийн дууны техникч Г.Мөнх-Эрдэнийг урьж дууны тоног төхөөрөмжийн ажиллагаа, дуужуулалтын чиглэлээр Уран бүтээл техникч албаны А.Батнягт, Өлзийжаргал нарт мэргэжлийн хичээл заалгаж, ажлын байрны сургалтад хамруулж, ур чадварыг нь дээшлүүллээ. Засгийн газрын үйлчилгээ аж ахуйн газраас зохион байгуулдаг ажлын байрны сургалтанд Маркетинг үйлчилгээний албаны 2 үйлчлэгчийг хамрууллаа.

Дээд байгуулагаас цаг үеийн шаардлагаар зохион байгуулагдаж буй сургалт, семинарт тухай бүрд оролцож ирлээ. Тухайлбал

2019 ОНЫ СУРГАЛТЫН ТАЙЛАН

Д/д	Хамрагдсан сургалтын сэдэв	Хамрагдсан огноо	Хамрагдсан ажилтан	Сургалт зохион байгуулсан газар
1	2	3	4	5
2	Нийслэлийн соёл урлагийн салбарын удирдах ажилтнуудыг чадавхжуулах	2019.01.10	Д.Баянзул	Нийслэлийн соёл урлагийн газар
3	Оюуны өмчийн талаар болон болон зохиогчийн эрхийн холбоотой мэдлэг мэдээлэл олгох уулзалт	2019.02.19	Д.Баянзул Б.Хонгор	Оюуны өмчийн газар
4	Нийслэлийн соёл урлагийн салбарын удирдах ажилтнуудыг чадавхжуулах	2019.03.15	Д.Мөнхбаяр Д.Баянзул	Нийслэлийн соёл урлагийн газар
5	Гамшгаас хамгаалах тухай хууль, тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, удирдах албан тушаалтнуудын мэдлэгийг дээшлүүлэх, гамшгаас хамгаалах талаар мэдээлэл хүргэх иж бүрэн сургалт	2019.03.15	Ж.Дуламжав Д.Баянзул	Нийслэлийн онцгой байдлын газар
6	Илтгэх ур чадварын үндэс	2019.04.03	Д.Баянзул	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
7	UB ERP системийн тухай сургалт	2019.05.10	Д.Баянзул Ж.Дуламжав	Нийслэлийн Мэдээлэл технологийн газар
8	Монгол улсын зохиогчийн эрхийн тогтолцоог сайжруулах нь үндэсний семинар	2019.05.16,17	Д.Баянзул Б.Хонгор	Дэлхийн Оюуны өмчийн газар, Монголын оюуны өмчийн газар
9	Үндэсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр удирдах албан тушаалтнуудад мэогэжил арга зүйн зөвлөгөө өгөх	2019.06.18	Ж.Дуламжав	Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар
10	Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг зохион байгуулах тухай	2019.06.18	Д.Цогжаргал	Нийслэлийн Архивын газар
11	Нутгийн захиргааны байгууллагуудад зориулсан худалдан авах ажиллагааны сургалт	2019.06.19	Ж.Дуламжав	Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар
12	Олон улсын Соёлын менежмент	2019.08.19	У.Урантогос Б.Хонгор Д.Баянзул Ц.Мөнхбаяр	Соёл урлагийн газар

13	Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн бэлтгэлийг хангахад зөвлөх нь	2019.08.21	Д.Цогжаргал	Нийслэлийн Архивын газар
14	Соёлын үйлчилгээний менежментийн чиглэлээр мэргэшүүлэх сургалт	2019.09	У.Урантогос Б.Хонгор Д.Баянзул Д.Болормаа	БНХАУ-ын Шилийн Гол хотын Ажил мэргэжлийн дээд сургууль
15	Компьютерийн сүлжээний анхан шат	2019.11.20	Д.Цогжаргал	Мэдээлэл технологийн үндэсний парк
16	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, хяналт, шалгалт	2018.11.29	Д.Гэрэлтуяа, Б.Байгалмаа	Нийслэлийн дотород аудитын газар

Тусламж, тэтгэмжийн чиглэлээр: Засгийн газрын 2004 оны 112 дугаар тогтоолоор батлагдсан төрийн албан хаагчдад тусламж олгох нөхцөл журам, байгууллагын дотоод журамд заасны дагуу гачигдалд тохиолдсон 5 хүнд **2400000** төгрөгийн буцалтгүй тусламж олголоо.

Ажлын байрны чиглэлээр: Маркетинг үйлчилгээний албанд үйлчлэгчээр Х.Ариунтуяа, Уран бүтээл техникийн албанд гэрэлтүүлэгчээр Б.Өлзийжаргал, Л.Нямцэрэн, А.Батцэнгэл, Б.Лхагвасүрэн, дууны оператораар Ч.Батчулуун, Соёл-Эрдэнэ хамтлагийн дуучнаар П.Өнөржаргал нарыг тус ажилд авч ажлын байраар хангалаа.

Албан хаагчдын шагнал, нийгмийн баталгааны чиглэлээр: Цагаан сарын баяраар ажил хөдөлмөрөөрөө шалгарсан техник сэлбэгийн нярав Р.Оюунчимэг Төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор, мужаан Б.Санчирхүү “Хөдөлмөрийн хүндэт” медалиар, Улсын баяр наадмаар цахилгааны засварчин Б.Лхагвадорж Төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор, дулааны диспетчер Ж.Баатархуяг “Хөдөлмөрийн хүндэт” медалиар, Соёл урлагийн ажилтны баяраар Уран бүтээл техникийн албаны дарга Д.Баянзул, Маркетинг үйлчилгээний албаны үйлчлэгч Г.Амартүвшин нар БСШУСЯ-ны жуух бичгээр тус тус шагнагдаж, Өргөөнд 32 жил ажилласан Ишийн Хишигжаргал өндөр насны тэтгэвэрт гарсантай холбогдуулж, хууль, журмын дагуу үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоос И.Хишигжаргалд нэг жилийн дундаж цалинтай тэнцэх **9151200** төгрөгийн тэтгэлэг, албан хаагчдын цалинд **365.7 сая**, үр дүнгийн урамшуулалд **51 сая** төгрөгийг, хоол, унаанд **64.0 сая** төгрөгийг олголоо.

3.5. Архив, албан хэрэг хөтлөлт, хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн талаар дараах ажлуудыг хийлээ. Үүнд:

1. 2018 оны захирамжлалын бичгүүдийг байгууллагын архивын системд оруулав.
2. 2019 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гарган байгууллагын НАГ-ын БНШК-оор хэлэлцүүлэн батлуулав.
3. 2018 онд батлуулсан устгах 11 хэргийн 96 хадгаламжийн нэгжүүдийг актын дагуу устгаж, Нийслэлийн Архивын газарт илтгэх хуудсаар хүргүүлэв.
4. Тусгай төрлийн баримтаар хэрэг бүрдүүлээгүй, хадгаламжийн нэгж үүсгээгүй байсныг эрж сурвалжлан олж хадгаламжийн нэгж бүрдүүлэх зааварчилгаа өгсөний дагуу, мөн байгууллагын 30 жилийн ойн арга хэмжээ, ном эмхэтгэл гаргахад зориулан байгууллагын үйл ажиллагаатай холбогдох гэрэл зураг, дүрс бичлэгийг цуглуулга байдлаар олж авсан. 30 жилийн ойн арга хэмжээний үйл ажиллагааны дараа хадгаламжийн нэгж үүсгэн, бүртгэлд орууллаа. Үүнд:

- ✓ Нийслэлийн архивын газраас зардлагдсан 2019.02.22-нд "Гэрэл зураг, кино, дүрс бичлэг, дуу авианы баримтаар хадгаламжийн нэгж бүрдүүлэх ажлын арга зүй" сэдэвт үзүүлэх сургалтад хамрагдав.
- ✓ Соёлын Төв өргөөний 20 жилийн ойн арга хэмжээний үеэр үзэсгэлэнд гаргасан 34ш зургуудад тайлбар бичин, 18 хуудас бүхий нэг альбоманд хийж хадгаламжийн нэгж болгон гэрэл зургийн цомгийн бүртгэл үйлдсэн.
- ✓ Соёлын Төв өргөөний 30 жилийн ойн арга хэмжээний үеэр үзэсгэлэнд гаргасан хөөсөнцрөөр зузаан болгосон 127 жаазтай зургуудыг нэг бүрчлэн бор дугтуйнд хийж гэрэл зургийн цомгийн бүртгэл үйлдсэн.
- ✓ Соёлын Төв өргөөний 30 жилийн ойн үеэр бий болсон цахим файл болон цахим зургуудыг ангилан дотоод товъёог үйлдэн цахим файлын 17ш CD/DVD, цахим зургийн 176ш зураг бүхий 2ш CD дээр буулган тус тус бүртгэл үйлдсэн.
- ✓ Соёлын төв өргөөний 30 жилийн ойд зориулсан дууг "Соёл-Эрдэнэ хамтлагийн дуучин МУГЖ Г.Жаргалсайханы дуулснаар 1ш CD дээр буулгаж дууны бүртгэл үйлдсэн.
- ✓ 2018 оны үйл ажиллагааны тайлангийн бичлэг болон 2008 оны 07 сарын 01-ний гэмт халдлагын дараах байдлын бичлэгийг бүртгэн 2ш DVD дээр буулган дүрс бичлэгийн бүртгэл үйлдсэн.
- ✓ Байгууллагын түүхэнд холбогдох одон тэмдэг, шагнал, үзмэрийн баримт, эд өлгийн зүйл, эрдэм шинжилгээний лавлах /ном, танилцуулга, тоглолтын билет, ...гм/-ыг заавар, зөвлөлгөө авч, нэр төрлөөр нь бүртгэлжүүлэх, тухай бүрд нь нэмэлт баяжилт хийж байна. Үүнд: Байгууллагын 30 жилийн ойгоор шагнагдсан нийслэлийн "Хангарьд" одон, МАН-ын "Тусгаар тогтнолын" одон, АН-ын "Эрх чөлөөний" одон, 30 жилийн ойгоор гаргасан ном, танилцуулга, тоглолтын тасалбарыг архивт бүртгэлжүүлэн хадгалав.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 150 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн Улсын үзлэг явуулах төв комиссын бүрэлдэхүүн, удирдамжийг батлах тухай 46 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн Нийслэлийн хэмжээнд Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн Улсын үзлэг зохион байгуулах тухай А/518 дугаар захирамжийн хүрээнд Дүүргийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн "Дүүргийн хэмжээнд Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн Улсын үзлэг зохион байгуулах тухай" А/246 дугаар захирамжийн дагуу байгууллагын захирлын А/04 дүгээр тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй байгууллагын комиссыг байгуулж ажиллаа.

Улсын үзлэгт бэлтгэхэд нийт **4,704,000** /дөрвөн сая долоон зуун дөрвөн мянга/-н төгрөг зарцуулсан ба "Улсын үзлэгт бэлтгэж хийх ажлын төлөвлөгөө"-г комиссын даргаар батлуулж комисс бэлтгэл ажлын явцад 3 удаа хуралдаж төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

2019 оны 08 сарын 28-ны өдөр хурлын танхимд /өрөөний дугаар-215/-д албан хаагчдад зориулсан албан хэрэг хөтлөлтийн сургалт зохион байгуулж, архивын улсын үзлэгт бэлтгэж буй явцыг дүгнэсэн.

1. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын хүрээнд хийсэн ажил

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 31-ний 05 дугаар тогтоолоор батлагдсан төрийн албан хаагчийн анкетийн загварын дагуу бүх албан хаагчдын хувийн хэргийг шинэчилсэн.

Бүх албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж 2019 оны 09 дүгээр сарын 09-ний захирлын А/13 тушаалаар баталсан ба хөдөлмөрийн гэрээг мөн шинэчлэн боловсрууллаа.

2. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны хүрээнд хийсэн ажил

Дүгнэх үндсэн үзүүлэлт тус бүрийн дагуу хэрэгжилтийг бэлтгэж ажилласан ба дараах томоохон ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

- eDoc программаас 2016-2018 оны ирсэн, явсан бичгийн бүртгэл хяналтын карт нөхөн хэвлэсэн
- “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь” гар утасны аппликейшныг байгууллагын баримт боловсруулдаг албан хаагчдад суулгаж тогтоолын хэрэгжилтийг хангасан илтгэх хуудас бичсэн.
- 2015 оноос хойших захирамжлалын баримт бичгүүдийн стандарт бүрдлийг шалгаж, боловсруулсан дардас дараагүй бичгүүд дээр нөхөн дарсан
- Байгууллагаас явуулсан бичгийн үлдэх хувийн баримтын бүрдлийг нягтлан, дутсан хавсралтуудыг edocпрограмаас хэвлэж ахин үдсэн
- 2015-2018 онд хамаарах дээд газраас ирсэн бичгийн бүртгэлийн дэвтэр нөхөн бүртгэсэн

3. Байгууллагын архивын ажлын хүрээнд хийсэн ажил

Дүгнэх үндсэн үзүүлэлт тус бүрийн дагуу хэрэгжилтийг бэлтгэж ажилласан ба дараах томоохон ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

- Архивт шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, тавиур шүүгээ, шаардлагатай материалаар хангаж 2 эгнээ бүхий 4ш нягтруулсан шүүгээгээр архивын өрөөг тоноглож, архивын өрөөнд галын хамгаалалт бүхий төмөр хаалгыг суурилуулсан
- Хадгаламжийн санд заагуур, заагчийг байрлуулсан
- “Архивын баримтын эрсдэлээс хамгаалах хөтөлбөр, төлөвлөгөө”-г шинэчлэн боловсруулсан
- 2015-2019 онд хамаарах архивын ажилтны сургалтын тайлан, техник хэрэгслийн жагсаалт, ном гарын авлагын жагсаалтын бэлтгэсэн.



4. Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх, цахим сан бүрдүүлж буй ажлын хүрээнд хийсэн ажил

Дүгнэх үндсэн үзүүлэлт тус бүрийн дагуу хэрэгжилтийг бэлтгэж ажилласан ба дараах томоохон ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

- 2015, 2017, 2019 оны захирамжлалын баримтуудыг arch.ulaanbaatar.mn системд оруулж нягтлан шалгасан.
- Epr.ulaanbaatar.mn- д хүний нөөцийн бүхий л хөдөлгөөнийг оруулсан.
- eDoc системд нэвтрэх нэр, нууц үгийг захирамжийн дагуу шинэчилсэн.
- Захирамжлалын баримтын нөөц хувийг DVD дээр хуулж тусгай төрлийн баримт үүсгэсэн.
- Байгууллагын вебсайтыг шинэчилж, боловсронгуй болголоо.

Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан Ц. Рэгээдмаа ахлагчтай нийслэлийн 5 дугаар ажлын хэсэг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж архивын улсын үзлэгийг 2019 оны 09 сарын 24-ний өдөр явуулсан.



Байгууллага нь 2019 оны улсын үзлэгт:

- Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт үзүүлэлтээр **90.6 % (A)**
- Албан хэрэг хөтлөлтийн талаарх үзүүлэлтээр **90 % (A)**
- Байгууллагын архивын ажил **91.3 % (A)**
- Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлж буй байдалд **90 % (A)** дүнтэй шалгагдаж, **нийт дүнгээр 90.4 % (A) дүнтэй үнэлэгдлээ.**



5. **Байгууллагад ирсэн хариутай албан бичгийн биелэлтийг хангаж**, 2019 онд 61 бичгийн хариуг хугацаанд нь шийдвэрлэсэн.
6. **Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар:**
 - ✓ Гаргасан өргөдөл, гомдлын талаар ирсэн ажлаас чөлөөлөх 15, ажилд авах 21, шилжүүлэн ажиллуулах тушаал 4, буцалтгүй тусламж олгох 7, ээлжийн амралт эдлүүлэх 24 тушаал гаргаж барагдуулан ажиллалаа.
 - ✓ Уран бүтээл техникийн албанд гэрэлтүүлэгч, гэрлийн оператор, албаны даргаар нийтдээ өргөөнд 32 жил ажилласан Ишийн Хишигжаргал нь 2019 оны 4 дүгээр сард өндөр насны тэтгэврээ тогтоолгож, улмаар Соёлын тухай хуульд заасан “нэг жилийн дундаж цалинтай тэнцэх хэмжээний тэтгэлэг” авах өргөдөл гаргасныг шийдвэрлэж, Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1997 оны 197/232 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Соёлын ажилтныг тэтгэвэрт гарахад нь тэтгэлэг олгох журам, 2 дугаар хавсралтаар батлагдсан “журамд хамаарах албан тушаалын жагсаалт”-ын 26, байгууллагын захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн протокол зэргийг баримтлан Сангийн сайдын 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 74 дүгээр тушаалын 1,2 дугаар хавсралтаарх төсвийн зарлагын хэмнэлтийн болон үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоос И.Хишигжаргалд нэг жилийн дундаж цалинтай тэнцэх **9151200** төгрөг /762600*12/-ийн тэтгэлгийг олголоо.
7. **Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр. 2019 оны 3 дугаар сард ОХУ-ын Буриад улсын Улаан-Үд хотын Байкал театрын гоцлол дуучин ОХУ-ын гавьяат жүжигчин, Буриад улсын ардын жүжигчин Дарима Дугдановагийн урлагт зүтгэсний 40 жилийн ойн хүндэтгэлийн арга хэмжээнд албаны дарга Д.Баянзул, дуучин Б.Хонгор нар,**
7 дугаар сард Улаан-Үд хотод болсон олон улсын ардын урлагийн “Голос Кочевников” наадамд албаны дарга У.Урантогос, Д.Баянзул, инженер Д.Мөнхбаяр, дуучин Б.Хонгор, тасалбар борлуулагч Б.Наранцэцэг, үйлчлэгч Ц.Тогтохжаргал, Ч.Мөнхтогтох, Ч.Заяа, Ч.Энхтуяа нар, 8 дугаар сард Засгийн Газрын Хэрэгжүүлэгч Агентлаг Соёл Урлагийн газар, ОХУ-ын Дорнод сибирийн соёлын менежментийн академитай хамтран зохион байгуулсан “Байкал-2019” зуны сургалтанд албаны дарга У.Урантогос, Д.Баянзул, дуучин Б.Хонгор нар



9 дүгээр сард болсон ӨМӨЗОрны Жининь хотод зохион байгуулагдсан ЕХРО-д албаны дарга Д.Баянзул, Ж.Дуламжав, дуучин Б.Хонгор, дууны

оператор Н.Тунгалаг, лифтчин Л.Болорчимэг нар, 11 дүгээр сард болсон Зууны манлай “Соёл-Эрдэнэ” хамтлагийг үүсэн байгуулагчдын нэг, Монголд хөгжмийн поп рок төрөл үүсэн хөгжих их суурийг тавьсан нэрт хөгжмийн зохиолч МУУГЗ Б.Наранбаатарын 70 насны ойг тохиолдуулан ОХ-ны Буриад улсын нийслэл Улаан –Үд хотноо зохион байгуулагдсан бүх шавь нар, мэргэжлийн урлагийн байгууллагууд оролцсон хүндэтгэлийн тоглолтонд дуучин Б.Хонгор, 12 дугаар сард БНХАУ-ын Хайнань хотод улсын 2 улсын Засгийн газраас зохион байгуулсан ЕХРО-гийн урлагийн хэсэгт албаны дарга Д.Баянзул тус тус оролцон ажлын туршлага солилцлоо.



Мөн 12 дугаар сарын 12-ны өдөр дуучин С.Нарангийн тайлан тоглолтоо хийсэн Япон улсын Гинза дүүргийн HULIC театр болон 1800 онд байгуулагдаад одоог хүртэл уран бүтээлээ туурвисаар буй үндэсний урлагийн театрын үйл ажиллагаатай танилцаж албаны дарга У.Урантогос, нярав Д.Энхмаа, нарийн бичгийн дарга Д.Цогжаргал, цахилгааны засварчин Б.Лхагвадорж нар тус тус оролцон ажлын туршлага солилцлоо.



Дөрөв. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал.

4.1. Төсөв, санхүүгийн ил тод байдлын хангаж, төсвийн хөрөнгийн батлагдсан төлөвлөгөө, зарцуулалтын сар улирлын мэдээ, тайлан балансыг цахимаар Нийслэлийн төрийн санд өгч, шилэн дансанд тухай бүр байршуулж, байгууллагын сайтад тавьж нийтэд толилуулж ирлээ.

Мөн түрээсийн буюу үзвэр үйлчилгээ, арга хэмжээний орлогоор үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлж, батлагдсан төсөв, үр дүнгийн гэрээний хүрээнд зардал гарган, төсвийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулж, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, хуулийн хугацаанд тайлагнаж хэвшлээ.

4.2. Үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, дараах ажлуудыг хийж, хэвшүүлээ.

4.2.1. Нийслэлийн Засаг даргын “Мэдээллийн ил тод байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 2012 оны А/606 дугаар захирамжийн дагуу байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг цаг тухайд нь цахим сайтад байршуулан, ил тод байдлыг хангаж ажиллаж ирлээ.

Мөн цаг үеийн мэдээллийн самбарыг ажилд оруулж өдөр тутмын ажил, тоглолтын график, ажлын дуудлага байрлуулж өдөр, тутмын шинэ мэдээ мэдээллээр хангаж, байгууллагын сайтыг тогтмол ажиллуулж хэвшүүлээ.

4.2.2. Үйлчилгээний ажлын ил тод байдлыг хангах зорилгоор санал, хүсэлт, сэтгэгдлийг нийтийн ариун цэвэр, угтах үйлчилгээ, үйлчилгээний ажилтны харилцааны соёлын чиглэлээр сэтгэл ханамжийн асуулгыг цахимаар болон 6 чиглэлийн асуулга хуудсаар авч хэвшүүлээ.

4.3 Хүний нөөцийн бодлогын ил тод байдлыг хангаж дараах ажлуудыг хийлээ.

4.3.1. Албан хаагчдын ёс зүйн дүрмийг болон ажлын байрны сул орон тооны зарыг цахим хуудас, мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулж, тухай бүр шинэчилж байна.

4.3.2. Төрийн албаны хуулийн өөрчлөлттэй холбогдуулан Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг дахин боловсруулах ажил эхлээд байна.

4.3.3. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг албадын үйл ажиллагааны онцлогийг харгалзан, албадын ажлын тайланг алба, нэгж бүрээр захирлын зөвлөлийн хурлаар оруулан хэлэлцүүлж, ажлын гүйцэтгэлийг нь дүгнэж, хэвшсэн. Улмаар албадын үйл ажиллагааны чиглэлээр нийт ажилчдын саналыг сонсож, дараа жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгаж, ажиллаж ирлээ.

Тав. Бусад мэдээлэл, Өөрсдийн санаачлагаар хийсэн ажлын тухай:

Нийслэлийн Соёлын Төв Өргөө нь “Соёл урлаг, шинжлэх ухаан, эдийн засаг, нийгмийн хөгжлийн олон талт арга хэмжээ зохион байгуулдаг, уран бүтээлчдийн хөгжин боловсрох, урлаг соёл, дуу хуур, амжилт бүтээлээ ард түмэндээ толилуулдаг “Монгол Улсын соёл урлаг, оюун ухааны гэгээрлийн төв” тайз нь болж хөгжиж ирлээ.

Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлог, туршлагыг дэлгэрүүлэх ажлууд хийгдэж байна. Тухайлбал: Манай байгууллагын үйлчилгээний зарчим, үйл ажиллагааны онцлогтой Эрдэнэт хотын “Уурхайчин” соёлын ордны хамт олон,

Увс аймгийн “Ойрад” театрын уран бүтээлчид, МАН-ын “Тусгаар тогтнолын ордон”-ны ажилтан, албан хаагч, Улсын драмын театрын үйлчилгээний ажилтнууд танилцаж, харилцан туршлага судаллаа. Тухайлбал:

1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд **“Соёлоо хуваалцсанд баярлалаа”** аяныг эхлүүлж, байгууллагын Вэбсайт болон Пэйж хуудсаар дамжуулан дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Аяны зорилго нь Нийслэлийн Соёлын Төв Өргөөнд зочлон ирж найз нөхөд, гэр бүлийнхэнтэйгээ жүжиг, концерт, хошин урлагийн тоглолт үзэн алжаал, ядаргаагаа тайлж, цагийг зөв боловсон өнгөрөөдөг **ЭРХЭМ ТА** дараах зөвлөмжүүдийг хүлээн авснаар **“соёлтой үзэгчийн эгнээнд багтаж, соёлыг түгээх эрхэм үйлсэд өөрийн биеэр оролцож байгаагаа** ойлгоно. Бид ч танд **“Соёлоо хуваалцсанд баярлалаа”** гэдгээ илэрхийлэх юм.

“Соёлоо хуваалцах” зөвлөмж

1-р зөвлөмж. Цагаасаа хоцрохгүй байх:

Үзвэр эхлэхээс 30 минутын өмнө ирээрэй. Үзэгчид суудлаа эзэлчихсэн тоглолт эхэлчихсэн байхад гар утасны гэрлээ тусган энэ хэддүгээр эгнээ вэ, хэддүгээр суудал вэ хэмээн асууж эхэлдэг. Хэрэв та тоглолт үзэхээр шийдсэн бол аль болох цагаасаа хоцрохгүй ирж сурах хэрэгтэй. Хоцорсон тохиолдолд Соёлын Төв Өргөөний үйлчилгээний ажилтнуудад тасалбараа үзүүлэн эгнээ болон суух суудлын дугаараа хаана гэдгээ мэдэн үзэгчдээс уучлалт гуйгаад, хүмүүсийн хажуугаар зөрөхдөө нүүрээ хүн рүү нь харуулж зөрөхийг хичээгээрэй.



Соёлоо хуваалцъя.

2-р зөвлөмж. Хоорондоо ярихгүй байх

Тухайн үзэж буй тоглолтын талаар өөрт төрсөн сэтгэгдэл болон мэдрэмжийнхээ тухай үзвэрийн дундуур биш үзвэрийн дараа ярих хэрэгтэй. Энэ нь соёлтой үзэгчийн нэг илэрхийлэл юм шүү.



Соёлоо хуваалцъя.

3-р зөвлөмж. Утсаар ярихгүй байх

Та тоглолт үзэхээр ирсэн бол гар утсаа унтрааж байх хэрэгтэй. Яаралтай хариу өгөх ажилтай бол утасныхаа дууг хааж хэвшээрэй гэрлийг нь багасган мессежээр хариу өгөөрэй. Тоглолт үзэж байхад хажуу хүн нь утсаар ярих нь бусдын анхаарлыг сарниулж таагүй сэтгэгдэл төрүүлдэг юм шүү.



Соёлоо хуваалцъя.

4-р зөвлөмж. Тоглолтын танхимд хурц үнэртэй хоол хүнсний зүйл идэхгүй байх

Үзвэрүүд ихэвчлэн орой 18:00, 19:00 цагаас эхэлдэг. Үзэгчид маань ажлаасаа таран шууд ирдэг. Соёлын төв өргөөнд түргэн хоолны жижиг газрууд 2 давхарт ажилладаг бөгөөд үзвэр эхлэхээс өмнө тухайн газартаа хоолоо идчихээд танхим руу ороорой. **Соёлоо хуваалцъя.**



5-р зөвлөмж. Суудлын араас хөндөхгүй /өшиглөхгүй/ байх

Үзвэр үзэж байхад араас нь өвдгөөрөө жийх нь таны өмнө сууж буй хүнд таагүй сэтгэгдэл үлдээдэг тул та урд талынхаа суудалд хүрэхгүй байх хэрэгтэй шүү.



Соёлоо хуваалцъя.

6-р зөвлөмж. Өлгүүр үрүү битгий яараарай

Үзвэр дуусах үед та өлгүүр үрүү битгий яараарай. Уран бүтээлчид танд баярлаж талархсанаа илэрхийлэн мэхийн ёслоход алга ташин тэдэнд урам зориг өгч дэмжээрэй. Тоглолт дууссаны дараа тоглолтын тухай ярилцаж зогсох нь таатай мэдрэмж шүү үзэгчдээ.



Соёлоо хуваалцъя.

7-р зөвлөмж. Үзвэр үзсэн танхимдаа хогоо битгий хаяарай.

Та уусан ундааны сав, идсэн чихэр, шоколадныхаа цаасыг суудлынхаа дор “мартчихсан” юм биш биз. Мэдээж цэвэрлэгээ хийх нь ойлгомжтой хэдий ч та өөрийнхөө тарьсан хогийг аваад гарах хаалганы дэргэдэх хогийн саванд ангилаад хийчихвэл бусдад үнэхээр сайхан санагдахаас гадна танд ч сайхан сэтгэгдэл үлдэнэ гэдэгт итгэлтэй байна.



Соёлоо хуваалцъя.



2. Монголын багш нарын VII Их Хурлын Төлөөлөгчдөд зориулсан хүндэтгэлийн тоглолтын үеэр нээлттэй хаалганы өдрийг зохион байгууллаа.

Монгол Улсын Ерөнхий сайд Ухнаагийн Хүрэлсүхийн ивээл дор болж буй Монголын багш нарын VII их хурал 2019 оны дөрөвдүгээр сарын 11-ний өдөр Төрийн ордонд эхэлж, Их хуралд Монгол Улсын 21 аймгийн 330 сум, нийслэлийн есөн дүүргээс сургуулийн өмнөх боловсролын 184, бага, дунд, тусгай хэрэгцээт, албан бус насан туршийн боловсролын 416, мэргэжлийн боловсролын 40, их дээд сургууль, коллежийн 68 багш төлөөлөгч оролцлоо.

2019 оны 4-р сарын 12-ны өдөр Монголын багш нарын VII их хурлын 800 төлөөлөгчдөд зориулсан мэргэжлийн урлагийн байгууллагуудын нэгдсэн хүндэтгэлийн тоглолт Нийслэлийн Соёлын Төв Өргөөний их танхимын тайзнаа амжилттай зохион байгуулагдлаа. Монголын багш нарын VII их хурлын төлөөлөгчдөд зориулж манай байгууллага хамт олон Соёлтой боловсон найрсаг үйлчилгээг үзүүлж бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллалаа.

Манай байгууллага нь 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулагдсан “Жендэр ба хөгжил” нийслэлийн анхдугаар чуулганд оролцож Жендерийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, төсөвлөлт, хяналт, шинжилгээ, үнэлгээний арга зүйг байгууллагынхаа үйл ажиллагаанд нэвтрүүлэн, жендерийн тэгш байдлыг хангаж “Жендерийн мэдрэмжтэй нийслэлийн харъяа байгууллага” цом, өргөмжлөлөөр шагнагдлаа.



Бид үзэгч, үйлчлүүлэгч, нийслэлчүүддээ байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээгээ танилцуулж, зөв боловсон үйлчлүүлж, “Соёлоо хуваалцах”- ыг уриалж, өлгүүрт хувцсаа өгөхдөө анхаарах зүйлс, орох, гарахад нь үүдний хэсэгт хогийн сав байрлуулсан байгааг сануулж, зөвлөж, хэрэгжүүлж байна.



Та бүхнийг, **эрдэм соёл, дуу хуурын хур буусан нийслэлийн соёл, урлагийн төв голомт болсон** манай байгууллагын “Төрөөс соёл, урлагийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, нийслэлийн өмч хөрөнгийн ашиглалтыг сайжруулж хөрөнгө нэмэх, нөхөх, үйлчилгээний соёлоо хангаж ажиллах чиглэлээр хийж байгаа бидний ажил”-ыг дэмжин, туслалцаа үзүүлж, хамтран ажиллана гэдэгт гүнээ итгэж байна.

ЗӨВШӨӨРСӨН:

ЗАХИРАЛ

Б.БАЙГАЛМАА

**НЭГТГЭН ГАРГАСАН:
ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН**

П.СЭРСМАА